



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2013 оны 02 сарын 06 өдөр

Дугаар 40

Улаанбаатар хот

Г Хорооны 2007 оны 156 дугаар тогтоолд Г
өөрчлөлт оруулах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.5 дахь заалт, Улсын Их Хурлын 2006 оны 45 дугаар тогтоолоор батлагдсан “Санхүүгийн зохицуулах хорооны дүрэм”-ийн 5.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Санхүүгийн зохицуулах хорооны 2007 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн “Үнэт цаасны зах зээлд оролцогч тусгай зөвшөөрөл бүхий этгээдээс төвлөрүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 156 дугаар тогтоолын хавсралтын хүснэгтийн 1 дэх мөрийг дор дурьдсан агуулгаар өөрчлөн найруулсугай:


1/ Хавсралтын хүснэгтийн 1 дэх мөр:


№	ЗОХИЦУУЛАЛТЫН ҮЙЛЧИЛГЭЭ		ЗОХИЦУУЛАЛТЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХӨЛС		
	ЗОХИЦУУЛАЛТЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХӨЛСӨД ХАМААРАХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ	ЭРХЭЛЖ БҮЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА	АРИЛЖАА, ГҮЙЛГЭЭ ХИЙГДСЭН ӨДӨР ТУТАМ /хувиар/	ТУХАЙН ЖИЛ БҮР /төгрөгөөр/	ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛСЭН ТУХАЙ БҮР /төгрөгөөр/
1	1.1 Арилжаа эрхлэх 1.2 Төлбөр тооцоо /биржийн ¹ /	1. а/ Хувьцаа 1.б/ Бусад үнэт цаас	Үнэт цаасны арилжааны гүйлгээнээс тусгай зөвшөөрөл бүхий мэргэжлийн байгууллагын олсон шимтгэлийн орлогын 10 хувь	-	-
	1.3 Брокер 1.4 Дилер	1. а/ Хувьцаа 1.б/ Бусад үнэт цаас	1.а/ Хувьцааны арилжааны худалдах, худалдан авах хэлцэл тус бүрийн үнийн дүнгийн 0,13 хувь 1.б/ Хувьцаанаас бусад үнэт цаасны арилжааны гүйлгээнээс олсон шимтгэлийн орлогын 10 хувь	-	-

2. Энэхүү тогтоолтой нийцүүлэн холбогдох дүрэм, журам, төлбөр тооцооны программд зохих өөрчлөлтийг ажлын 10 хоногт багтаан оруулж, зохицуулалтын үйлчилгээний хөлсийг 2013 оны 02 дугаар сарын 25-ны өдрөөс эхлэн тооцож, Хорооны дансанд төвлөрүүлж ажиллахыг “Монголын хөрөнгийн бирж” ХК /Х.Алтай/, “ҮЦТТГХТ” ХХК /Т.Гандулам/-д тус тус үүрэг болгосугай.

000041

3. Тогтоолын хавсралтад өөрчлөлтийг оруулж, хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА  Д.БАЯРСАЙХАН



The stamp is rectangular with a double-line border. Inside, there is a central emblem featuring a traditional Mongolian pattern. On either side of the emblem, there is vertical text in Mongolian script. The text on the left reads 'МОНГОЛ УЛСЫН Шүүх байгууллага' and the text on the right reads 'Мэдээлэл, харилцаа, олон нийтэд мэдээлэх ажил'.